



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/391

Булган сум

Согтууруулах ундаа худалдах,  
түүгээр үйлчлэхийг хориглох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.10, 28.1.12 дахь заалт, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан аймгийн хэмжээнд 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдөр согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглосугай.

2. Захирамжид дурдсан хугацаанд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхгүй байхыг согтууруулах ундаа худалдах, үйлчлэх үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Одхүү), Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа Б.Эрдэнэбилэг), сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д. ПУГЭВ-ОЧИР



6326010528